# ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

2021 ОН

ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ
\2021-2025\

## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Төрийн албаны тухай хуулийн 53-р зүйл, Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор баталсан "Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам"-ын хэрэгжилтийг хангах, Монгол улсын Засгийн газрын бодлого шийдвэрийг аймаг орон нутгийн онцлогт тохируулан хэрэгжүүлэх, ажлын уялдаа холбоог хангах зорилгоор "Алсын хараа 2050" урт хугацааны бодлогын баримт бичиг, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Хэнтий аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан байгууллагын Стратеги төлөвлөгөөг боловсруулав.

## ХОЁР. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ

| НИЙГМИЙН БОДЛОГЫН ЧИГЛЭЛЭЭР | | |
|---|---|---|
| Салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хуулийн тоо | | 35 |
| Үүнээс: | Тухайн салбарын хуулийн тоо | Боловсрол-2<br>Эрүүл мэнд-9<br>Соёл, спорт-4<br>Хөдөлмөр, нийгмийн хамгаалал-10 |
| | Нийтлэг мөрддөг хуулийн тоо | 9 /Монгол Улсын засаг, захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн албан хаагчийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль/ |
| Ерөнхий чиг үүрэг-1: Боловрол<br>Нутаг дэвсгэртээ боловсролын талаархи төрийн бодлого, хууль тогтоомж, тухайн Хурлын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах; | | |
| Үндсэн чиг үүрэг | Дэд чиг үүрэг | Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид |
| ҮЧҮ-1: Орон нутгийн өмчийн боловсролын сургалтын байгууллага байгуулах, өөрчлөх, татан буулгах | Бэрх хотод олон улсын хөтөлбөртэй ерөнхий боловсролын сургалтын чанарын стандартыг дэлхийн жишигт нийцүүлэх зүүн бүсийн аймгуудын төв сургууль байгуулна. | БСУГ, БШУЯ, АЗДТГ |

| | | |
|---|---|---|
| асуудлыг аймаг, нийслэлийн боловсролын газрын дүгнэлтийг үндэслэн шийдвэрлэх;<br>/Боловсролын тухай хуулийн 30.1.3/ | Судалгаанд үндэслэн зарим сургуулийн хэв шинжийг өөрчилнө. | БСУГ |
| ҮЧҮ-2: Иргэнд суурь боловсрол эзэмшүүлэх, мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх, давтан сургах, мэргэжил эзэмшүүлэх арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх;<br>/Боловсролын тухай хуулийн 30.1.2/ | Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш, ажилтны нийгмийн болон хөдөлмөрийн үнэлэмжийг нэмэгдүүлэх зорилгоор “Чадварлаг багш, чанартай боловсрол” арга хэмжээг хэрэгжүүлнэ | БСУГ |
| ҮЧҮ-2: | Боловсролын байгууллагын удирдах албан тушаалтнуудын мэдлэг боловсролыг дээшлүүлэх сургалтыг жил бүр зохион байгуулж, сургалтын үр дүнг ажлын гүйцэтгэл дээр тулгуурлан үнэлж дүгнэнэ. | БСУГ |
| | Бүх насны суралцагч, иргэдэд зориулсан онлайн сургалтын сантай болж, цахим сургалт зохион байгуулж, иргэдийн 30 хувьд хүрч ажиллана. | БСУГ, Насан туршийн боловсрол төв |
| | Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдийн гарааны үнэлгээг жил бүр шинэчлэн тогтоож сургалтын чанарыг 5,5 хувиар ахиулж үр дүнг тооцно | БСУГ |
| ҮЧҮ-3: Орон нутгийн мэргэжилтэй ажилтны хэрэгцээг хангах зорилгоор нутгийн захиргааны байгууллагаас дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид зориулсан санхүүгийн дэмжлэг олгож болох бөгөөд уг дэмжлэгийн төрөл, хэмжээ, олгох нөхцөл, журмыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтоож, тухайн жилийн төсөвтөө тусган санхүүжүүлнэ.<br>/Боловсролын тухай хуулийн 30.1.2, | Орон нутагт шаардлагатай мэргэжлээр суралцаж байгаа оюутнуудад сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлнэ. | Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуй нэгж байгууллага |

| | | |
|---|---|---|
| Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5/ | | |
| ЧҮ-4: Цэцэрлэгийг зориулалтын барилга байгууламжаар, ерөнхий боловсролын сургуулийг хичээлийн болон дотуур байраар хангах, дотуур байрны хүүхдийн хоол хүнсний хангамжийг зохих журмын дагуу шийдвэрлэх; /Боловсролын тухай хуулийн 0.1.13/ | Шаардлагатай сургууль, цэцэрлэг, дотуур байрны орчин нөхцөлийг сайжруулж зориулалтын тоног төхөөрөмжөөр хангана. | БШУЯ, БХБГ, БСУГ |
| | Хэрлэн сумын яслийн барилгыг 100 ороор өргөтгөж, шаардлагатай сумдын цэцэрлэгт яслийн бүлэг ажиллуулна. | БСУГ, сумын цэцэрлэгүүд |
| ҮЧҮ-5 Төрийн бус өмчийн боловсролын сургалтын байгууллагад хууль тогтоомжид заасан дэмжлэг, туслалцаа үзүүлэх; /Боловсролын тухай хуулийн 30.1.5/ | ”Тогтвортой хөгжлийн боловсрол II” төслийг Ерөнхий боловсролын 5 сургуульд хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. | БОМСТ |
| | Багш хөгжлийн төв байгуулж насан туршийн боловсрол төвийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, орчин нөхцөлийг сайжруулна. | БШУЯ |
| ҮЧҮ-6 Өөрийн орлогоо нэмэгдүүлэхэд нь боловсролын байгууллагад дэмжлэг үзүүлэх, тэдгээрийг хичээлийн болон дотуур байр, сургалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, ном, сурах бичгээр хангах ажлыг зохион байгуулах /Боловсролын тухай хуулийн 30.1.4/ | Суралцагчдын мэдээлэл технологийн чадварыг сайжруулах зорилгоор ЕБС-ийн 1 компьютерт ногдох хүүхдийн тоог бууруулж, сургуулиудын интернэт хурдыг нэмэгдүүлнэ. | Сумын Засаг дарга нар |
| Ерөнхий чиг үүрэг-2: Соёл, спортын чиглэлээр<br>Соёл, биеийн тамир, спортын талаархи төрийн бодлого, хууль тогтоомж, тухайн Хурлын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах | | |
| Үндсэн чиг үүрэг | Дэд чиг үүрэг | Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид |
| ҮЧҮ-1 Соёлын байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулж, хууль тогтоомжид заасны дагуу санхүүжүүлэх, тэдэнд дэмжлэг туслалцаа үзүүлэх, ажиллагчдын | Аймгийн музейн барилгыг ашиглалтад оруулж, үзмэрийг шинээр дэглэж, Сэцэн ханы ордон музейг хуучны загварт оруулж, сэргээн засварлана. | БСУГ, Музей, ЗДТГ |

| | | |
|---|---|---|
| нийгмийн баталгааг хангах арга хэмжээ авах /Соёлын тухай хуулийн 14,2,2/ | | |
| ҮЧҮ-2 Төрийн соёлын бодлого, соёлын хууль тогтоомжийн дагуу соёл урлагийг хөгжүүлэх, иргэдийн соёлын эрэлт хэрэгцээг хангах, түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалахад чиглэсэн арга хэмжээг хөтөлбөртөө тусгаж, хэрэгжүүлэх; /Соёлын тухай хуулийн 14.2.1/ | Монгол үндэсний спортын уламжлалт соёлыг дээдэлж, орон нутагт зохион байгуулах арга хэмжээнд дэмжлэг үзүүлнэ. | БТСГ, сумын ЗДТГ, иргэд |
| ҮЧҮ-3 Төрийн соёлын бодлого, соёлын хууль тогтоомжийн дагуу соёл урлагийг хөгжүүлэх, иргэдийн соёлын эрэлт хэрэгцээг хангах /Соёлын тухай хуулийн 14.2.1/ | Хэнтий аймгийн онцлог, соёл иргэншил, үнэт зүйлийг танилцуулсан өв, соёл, урлагийн бүтээлийг дэмжин хөгжүүлнэ. | БСУГ, АДБХХЧуулга |
| ҮЧҮ-4 Засаг дарга харьяалах нутаг дэвсгэрийн хүн амын соёлын үйлчилгээг сайжруулах ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах, соёлын талаархи иргэний журамт үүргийн биелэлтийг хангуулах арга хэмжээг хэрэгжүүлнэ. /Соёлын тухай хуулийн 14.3 / | Хэнтий аймгаас төрөн гарсан алдартнуудын амьдрал, гавьяа зүтгэлийг сурталчилсан бүтээлийг дэмжиж ажиллана. | БСУГ, Баян-Адарга сумын ЗДТГ, Музей, Архилогийн хүрээлэн |
| ҮЧҮ-5 Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийг олж тогтоох, олон нийтэд таниулах, дэмжлэг үзүүлэх, өвлөн уламжлуулах ажлыг зохион байгуулах; /Соёлын өвийн тухай хуулийн 16.1.12./ | Хан Хэнтий нутгийн түүх, соёлын биет болон биет бус өвийг хадгалж, хамгаалах, өвлүүлэх цахим мэдээллийн сан бүрдүүлнэ. | БСУГ, Музей, сумын засаг дарга, Соёлын төвүүд, |
| ҮЧҮ-6 Төрийн соёлын бодлого, соёлын хууль тогтоомжийн дагуу соёл урлагийг хөгжүүлэх, иргэдийн соёлын эрэлт хэрэгцээг хангах, түүх, соёлын | Иргэдийг соён гэгээрүүлэх, хүүхэд залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэхэд бүх нийтийн оролцоог хангаж “Хэнтийн түүх-бидэнд чухал” арга хэмжээг жил бүр зохион байгуулна. | БСУГ, ГБХЗХГ, ЕБС, СӨБ, Төрийн болон төрийн бус байгууллага, соёл урлагийн байгууллагууд, иргэд, |

| | | |
|---|---|---|
| дурсгалт зүйлийг хамгаалахад чиглэсэн арга хэмжээг хөтөлбөртөө тусгаж, хэрэгжүүлэх; /Соёлын тухай хуулийн 14.2.1/ | | |
| ҮЧҮ-7 Хүн амын нягтаршил, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн иргэний идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх боломжийг бий болгох, спортын барилга байгууламж, заал, талбайн хүрэлцээ, хангамжийг нэмэгдүүлэх, бэхжүүлэх /Биеийн тамир, спортын тухай хуулийн 8.1.6/ | "Олимп" цогцолборын орчин нөхцөлийг сайжруулж, үйл ажиллагааг тогтмолжуулна. | БТСГ, Хэрлэн сумын ЗДТГ, Төрийн бус байгууллага, иргэд |
| ҮЧҮ-8 Харьяа нутаг дэвсгэртээ иргэнийг идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх нөхцөлийг бүрдүүлэх Биеийн тамир, спортын тухай хуулийн 8.1.2/ | Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа спорт клубуудийг магадлан итгэмжлэлд оруулж, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих нөхцөлийг бүрдүүлэн спортоор хичээллэдэг иргэдийн тоог нэмэгдүүлнэ. | БТСГ, Хэрлэн сумын Засаг дарга, ЭМНДХ, спортын холбоод, Клуб |
| ҮЧҮ-9 Биеийн тамир, спортыг хөгжүүлэх чиглэлээр спортын холбоод, бусад байгууллагатай хамтран ажиллах Биеийн тамир, спортын тухай хуулийн 8.1.7/ | Нийтийг хамарсан үндэсний болон нийтийн биеийн тамир, бүх нийтийн спортын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудыг түшиглэн биеийн тамираар хичээллэгсэдийг нэмэгдүүлнэ. | БТСГ, Сумын Засаг дарга, ЭМГ, БСУГ, ХГБЗХГ, Спортын холбоод, клуб |
| ҮЧҮ-10 Харьяа нутаг дэвсгэртээ иргэнийг идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх нөхцөлийг бүрдүүлэх; Биеийн тамир, спортын тухай хуулийн 8.1.2/ | Өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагааг клубын системд шилжүүлнэ. | БТСГ, БСУГ, ХГБЗХГ, Спортын холбоо, клуб |

| Ерөнхий чиг үүрэг-4: Хүн амын нийгмийн хамгааллын хөтөлбөрийг боловсруулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, аж ахуйн нэгж байгууллагуудыг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хэрхэн сахиж байгаад хяналт тавих ажлыг зохион байгуулах /Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хуулийн 29 дүгээр зүйл/ | | |
|---|---|---|
| Үндсэн чиг үүрэг | Дэд чиг үүрэг | Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид |
| ҮЧҮ-1: Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалд хамруулах ажлыг орон нутгийн байгууллага хариуцан зохион байгуулна. /Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай 6.1./ | Иргэдэд нийгмийн даатгалын ач холбогдолыг сурталчлан даатгуулагчдын тоог нэмэгдүүлнэ. | НДХ, сумын ЗДТГ, Ажил олгогчид, хэвлэл мэдээлэл |
| ҮЧҮ-2: Эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах; /Эрүүл мэндийн даатгалын тухай 16.1.1./ | Эрүүл мэндийн даатгалын ач холбогдлыг сурталчлан даатгуулагчдын тоог нэмэгдүүлнэ | АЗДТГ, ЭМДХ, Сумын ЗДТГ, Багийн Засаг дарга, Ажил олгогчид, хэвлэл мэдээллийн байгууллаг |
| ҮЧҮ-3: Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний шалтгааныг судалж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах /ХАБЭА-н тухай хуулийн 25 дугаар зүйл/ | Сумдын ХАБЭА-ын зөвлөлөөр дамжуулан хяналтыг сайжруулж үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлнэ. | ХХҮГ, НДХ, МХГ, Сумдын ЗДТГ, аж ахуйн нэгж байгууллагууд |
| ҮЧҮ-4: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд хамрагдах ажил олоход хүндрэлтэй иргэдийн талаарх мэдээлэл, судалгааг гаргаж, хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээг тодорхойлох, хөдөлмөр эрхлэлтийн | Бүтээн байгуулалтын томоохон төслүүдийн үр дүнд шинэ ажлын байрыг 450-аар нэмэгдүүлнэ.<br>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих "Бизнесээ эхэл" арга хэмжээг хэрэгжүүлнэ.<br>Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг өрхийн насанд хүрсэн хөдөлмөрийн чадвартай гишүүдийг хөдөлмөр | ХХҮГ, МСҮГ, Сумдын ЗДТГ, ОУБ, ХХААГ, ААНБ-ууд |

| | | |
|---|---|---|
| нийтлэг үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд хамруулах /Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 30 дугаар зүйл/ | эрхлэх боломжоор хангах "Халамжаас-Хөдөлмөрт" бэлтгэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.<br>Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт болон байгууллага иргэдийн захиалгаар оюутнуудыг бэлтгэн төгсөгчдийн 50-аас доошгүй хувийг ажлын байраар хангана. | |
| ҮЧҮ-5: Дэд бүтэц, нийтийн зориулалттай барилга байгууламжийг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй байлгах, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль тогтоомжийг сурталчлах /Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 42 дугаар зүйл/ | Тусгай хэрэгцээ шаардлагатай иргэдийн орчны хүртээмжийг сайжруулж, орчин бүрдүүлсэн байгууллага, аж ахуйн нэгжийн тоог нэмэгдүүлнэ. | ХХҮГ, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоод, Сумдын ЗДТГ |
| ҮЧҮ-6: Аймгийн төвд ахмадын ордон, сумдад ахмадын өргөө, танхим байгуулж ажиллуулах, түүнд шаардагдах хөрөнгө, үйл ажиллагааны зардлыг тухайн орон нутгийн төсөвт жил бүр тусгах, /Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйл, МУЗГ-ын 2017 оны 197 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт/ | Ахмадын хөгжлийн төв болон ахмад настны чадамжийг дэмжиж 178 байгууллагад ахмадын сан байгуулна. | ХХҮГ, Төрийн байгууллагууд |
| ҮЧҮ-7: Хүүхдэд зориулсан үйлдвэрлэл, үйлчилгээ, сургалт, хүмүүжлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих, хүүхдийн авьяас, чадварыг хөгжүүлэх, чөлөөт цагийг үр ашигтай өнгөрүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээ авах, хүүхдэд зориулсан барилга байгууламжийн ашиглалтад хяналт тавьж, зориулалтын дагуу | Хүүхдэд ээлтэй орон нутгийн 6 шалгуур үзүүлэлтийн хүрээнд хүүхдийн хөгжлийг дэмжиж, эрсдэлд нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлж Хүүхдэд ээлтэй орон нутаг болно. | ГБХЗХГ, Сумдын ЗДТГ, ОУБ, ЭМГ, БСУГ |

| | | |
|---|---|---|
| ашиглуулах, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг түр байршуулах, асрамжлах, шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлэх<br>/Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйл/ | | |
| ҮЧҮ-8: Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах, хүчирхийллийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх, орон нутгийн төсвийн хөрөнгөөр нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байр байгуулах хохирогчид үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулах, нийгмийн ажилтныг хохирогчтой ганцаарчлан уулзах өрөө, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх<br>/Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 19 дүгээр зүйл/<br>/Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.6/ | Жендэрийн чиглэлээр орон нутагт тулгамдаж байгаа асуудлуудыг шийдвэрлэх болон гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчдод цогц үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ. | ГБХЗХГ, Сумдын ЗДТГ, ОУБ, ИНБ |
| ҮЧҮ-9: Залуучуудыг бие даан амьдрах, нийгэм, эдийн засгийн эрсдэлээс хамгаалахад чиглэсэн мэдээлэл, сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээг тэдний оролцоо, дэмжлэгтэйгээр зохион байгуулах, Залуучуудын соёл, боловсрол, иргэний үүрэг, хариуцлагыг | Залуучуудын хөгжлийн төвийн үйл ажиллагаагаар дамжуулан жил тутам залуучуудын оролцоог 50 хувиар, үйл ажиллагаанд хамрагдалтыг 10 хувиар нэмэгдүүлнэ.<br>Төр-Иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагааг нэмэгдүүлж, төрийн зарим чиг үүргийг иргэний нийгмийн байгууллагаар гүйцэтгүүлнэ. | ГБХЗХГ, Сумдын ЗДТГ, ОУБ, ИНБ сүлжээ ТББ-ууд |

| | | |
|---|---|---|
| дээшлүүлэх ажлыг зохион байгуулах, Залуучуудын хүмүүнлэгийн болон сайн дурын ажилд оролцох оролцоог дэмжих. /Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 21 дүгээр зүйл/ | | |
| Ерөнхий чиг үүрэг-1: Эрүүл мэнд<br>Засгийн газар, нутгийн өөрөө удирдах байгууллагаас гаргасан шийдвэрийн биелэлтийг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах, хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, ойрын ба хэтийн төлөвийг төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулах; | | |
| Үндсэн чиг үүрэг | Дэд чиг үүрэг | Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид |
| Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар арга хэмжээг зохион байгуулах | “Ковид-19” болон халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, сургалт сурталчилгаа, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хариу арга хэмжээний бэлэн байдлыг 92 хувьд хүргэнэ. | АЗДТГ, Сумын ЗДТГ, өрх, сумын ЭМТ |
| Байгалийн онц аюултай үзэгдэл болон олон улсын хөл хориот өвчин гарсан тохиолдолд шаардлагатай арга хэмжээг шуурхай авах; | Хариу арга хэмжээний нөөцийн бэлэн байдлыг бүрдүүлнэ. | АЗДТГ, СЗДТГ, ОБГ, НЭ, ЗӨСТ, УАУЭ, өрх, сумын ЭМТөв |
| Хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих чиглэлээр төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллана. | Нийт хүн амын 65%-ийг, зорилтот бүлгийн 70%-ийг эрүүл мэндийн боловсрол олгох сургалтад, үзлэг, шинжилгээнд хамруулна. | АЗДТГ, Нэгдсэн эмнэлэг СЗДТГ, өрх, сумын ЭМТ, ИНБ |
| | Уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээний төрлийг нэмэгдүүлж, орон нутгийн анхан шатны эмч, мэргэжилтний 85 хувийг сургагч багшаар бэлтгэнэ. | УАУЭ |
| “Шинэ болон сэргэн тархаж байгаа халдвартай тэмцэх стратеги”-ийн бодлого, үйл ажиллагааны чиглэлтэй уялдуулан шинэ болон сэргэн тархаж байгаа халдварын тандалт, хяналт, | Хеликобактеритай тэмцэх, хянах арга хэмжээг хэрэгжүүлж нянгийн шалтгаант ходоодны архаг үрэвслийг эрт илрүүлж, түүнээс үүссэн өвчлөлийн хүндрэлээс сэргийлэх арга хэмжээ зохион байгуулна. | АЗДТГ, сумын ЗДТГ, НЭ, өрх, сумын ЭМТ |

| | | |
|---|---|---|
| хариу арга хэмжээний бэлэн байдлын чадавхийг нэмэгдүүлэх | | |
| Хүн амын дунд сүрьеэ өвчнийг эрт илрүүлж, бүрэн эмчлэх | Сүрьеэ, БЗДХалдварын эрт илрүүлэлтийг эрчимжүүлэн, эмчилгээний үр дүнг 90-с доошгүй хувьд хүргэнэ. | АЗДТГ, сумын ЗДТГ, НЭ, өрх, сумын ЭМТ |
| Хавдрын бүртгэл, мэдээлэл, эргэн дуудаж хянах ажил болон хорт хавдрыг оношлох, чадавхыг нэмэгдүүлэх | Гуравдугаар шатлалын эмнэлэгтэй хамтран зонхилон тохиолдож буй хавдрыг эрт илрүүлэх арга хэмжээг зохион байгуулж, 45-с дээш насны иргэдийн 70-с доошгүй хувийг хамруулна. | НЭ, ХСҮТ, 3-р шатлалын эмнэлэг, өрх, сумын ЭМТ |
| Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндэд ээлтэй орчин бүрдүүлэх, эх, хүүхдийн сэргийлж болох эндэгдлийг бууруулахад бусад салбарын чиг үүргийг тодорхойлж, хамтран ажиллах; | "Эрүүл ирээдүй", "Эх хүүхдийн эрүүл мэнд" арга хэмжээг салбар дундын оролцоотой зохион байгуулж 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг 1 промилиор бууруулна. | АЗДТГ, сумын ЗДТГ, НЭ, өрх, сумын ЭМТ, БСУГ, хамтарсан баг |
| Монгол Улсын 15-аас дээш насны иргэдийг хепатитийн В, С вирусийн халдвар илрүүлэх шинжилгээнд үе шаттай хамруулж, халдвартай хүн амыг эмчлэх, халдваргүй нь тогтоогдсон хүн амыг урьдчилан сэргийлэх хөтөлбөрт хамруулсан байна. | "Элэг бүтэн Монгол" арга хэмжээг хэрэгжүүлж, элэгний Д вирусийн халдвартай иргэдийн 55-с доошгүй хувийг эмчилгээнд хамруулна. | АЗДТГ, сумын ЗДТГ, НЭ, өрх, сумын ЭМТ, ЭМДХ |
| Эрчүүдийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах, сургалт сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах | "Эрчүүдийн эрүүл мэнд" арга хэмжээг зохион байгуулж, нийт эрчүүдийн 60-с доошгүй хувьд хүрч ажиллана. | АЗДТГ, сумын ЗДТГ, НЭ, өрх, сумын ЭМТ |
| Харьяалах нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагад нэмэлт санхүүжилт олгох; | Яаралтай тусламжийн бэлэн байдал, тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн стандартын хангалтыг 10 хувиар нэмэгдүүлнэ. | АЗДТГ, Сумын ЗДТГ, өрх, сумын ЭМТ |
| | Эрүүл мэндийн байгууллагуудын шаардлагатай барилга, автомашин, багийн эмчийг унаажуулах асуудлыг үе шаттай хэрэгжүүлнэ. | АЗДТГ, сумын ЗДТГ, УАУЭ, өрх, сумын ЭМТ |

<table>
<tr><td colspan="2"></td><td>ЭМБайгууллагад цахим үйлчилгээг бүрэн нэвтрүүлж, оношилгоо, эмчилгээнд алсын зайн технологи ашиглаж, мэдээллийн сан үүсгэнэ.</td><td>ЭМГ</td></tr>
<tr><td colspan="2">Засгийн газар, нутгийн өөрөө удирдах байгууллагаас гаргасан шийдвэрийн биелэлтийг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах;</td><td>Орон нутгийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн эмийн бодлогыг хэрэгжүүлж, эмийн зохистой хэрэглээг сурталчилж, эрүүл мэндийн байгууллага бүр антибиотикийн хэрэглээнд хяналт тавих ажлыг зохион байгуулна.</td><td>АЗДТГ, сумын ЗДТГ, МХГ, ЭМДХ, өрх, сумын ЭМТ, ЭМДХ, УАУЭ, хувийн хэвшил</td></tr>
<tr><td colspan="4">Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс/</td></tr>
<tr><td colspan="2">Салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хуулийн тоо</td><td colspan="2">19</td></tr>
<tr><td rowspan="2">Үүнээс:</td><td>Тухайн салбарын хуулийн тоо</td><td colspan="2">10</td></tr>
<tr><td>Нийтлэг мөрддөг хуулийн тоо</td><td colspan="2">9</td></tr>
<tr><td colspan="4">Ерөнхий чиг үүрэг-1: Нутаг дэвсгэрийн хэмжээнд газар зохион байгуулалтын төлөвлөлтийг сайжруулж төр хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар орон сууц, олон нийтийн барилга түүнтэй холбогдох дэд бүтэц, тээвэр ложистикийн байгууламжийг байгуулах, үйлчлэх хүрээг өргөтгөх бодлого боловсруулж хэрэгжилтийг хангаж ажиллана. / МУЗЗНДНэгжийн хууль 29.1.1./</td></tr>
<tr><td colspan="2">Үндсэн чиг үүрэг:</td><td>Дэд чиг үүрэг</td><td>Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид</td></tr>
<tr><td colspan="2">ҮЧҮ-1: Газрын талаар төрөөс явуулах нэгдсэн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлж, газрыг үр ашигтай, зохистой ашиглуулах, хяналт тавих, зөрчлийг арилгуулах, аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулж аймгийн ИТХ-аар батлуулж ажиллана.</td><td>Аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинээр батлуулан мөрдүүлж хүрээлэн буй орчинд ээлтэй суурьшлын болон үйлдвэрлэлийн бүсчлэлийг тогтоон хөгжүүлнэ.</td><td>ГХБХБГ, СЗДТГ</td></tr>
<tr><td colspan="2" rowspan="2">ҮЧҮ-2: Орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах, иргэдийг орон сууцаар хангах бодлого тодорхойлж, хэрэгжилтэд хяналт тавина;</td><td>Анх удаа орон сууц худалдан авч байгаа холбогдох шаардлагыг хангасан 300-аас доошгүй иргэдийг хөнгөлөлттэй зээлд хамруулна.</td><td>ГХБХБГ, СЗДТГ</td></tr>
<tr><td>120-оос доошгүй айлын түрээсийн орон сууцны барилгын ажлыг эхлүүлнэ.</td><td>ГХБХБГ, СЗДТГ</td></tr>
</table>

| | | |
|---|---|---|
| | Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд орон сууцны барилга барих санал санаачилгыг дэмжинэ. | ГХБХБГ, СЗДТГ |
| ҮЧҮ-3: Холбогдох хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрийг харьяалах нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх, Орон нутагт дахь эрчим хүч, цэвэр, бохир усны болон зам, замын байгууламж, тээвэр, харилцаа холбооны шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламж бүхий “инженерийн дэд бүтэц”-ийг өргөтгөх, шинэчлэн байгуулах, найдвартай, хүртээмжтэй байдлыг хангаж, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлнэ. | 3.5.4. Чингис хотын ус хангамжийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, барилга байгууламж, тоног төхөөрөмжийг шинэчлэн өргөтгөх, шинээр худаг гаргах замаар баталгаат ундны усны тоог нэмэгдүүлнэ. | ГХБХБГ, “Хэнтий Ус” ХХК |
| | 3.5.5. Чингис хотын үерийн байгууламжийг ашиглалтад оруулж, хот доторх ус зайлуулах сувгийг бий болгоно. | |
| | 6.1.5. Чингис хотын гэр хорооллын худгуудыг төвлөрсөн цэвэр усанд холбож, ухаалаг систем суурилуулна. | |
| | 6.2.4. Сумдын ундны усны эх үүсвэрийг нэмэгдүүлж, худгуудыг төвлөрсөн цэвэр усанд холбож, ухаалаг систем суурилуулна. | |
| | 3.5.6. Шилэн кабелийн сүлжээг өргөтгөж, хурдыг сайжруулна. | НҮҮСан, хувийн хэвшил |
| | 3.5.7. Дулааны станцыг ашиглалтад оруулна. | “БЗӨБЦТС” ТӨХК, төсөл хөтөлбөр, ГХБХГ, АТТ, Шуудан үйлчилгээний газар, ИНЕГ Хэнтий Ус ХХК |
| | 3.5.8. Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр болох нар, салхины сэргээгдэх эрчим хүчний хэрэглээ ашиглалтыг нэмэгдүүлнэ. | |
| | 3.5.9. Шаардлагатай багийн төвүүд болон шинээр олгогдсон өмчлөлийн газруудад 04 кв-н цахилгааны шугам тавина. | |
| | 6.1.1. Дулааны станцын гадна инженерийн хангамжийн ажлыг гүйцэтгүүлнэ. | |
| | 6.1.2. Чингис хотын 2-р хэлхээний шугам сүлжээг үе шаттай гүйцэтгэнэ. | |
| | 6.1.3. Чингис хотын 110/35/10-ын дамжуулах станцаас ЦТСС хүртэлх ЦДАШ-ыг газарт буулгах ажлыг хэрэгжүүлнэ. | |
| | 3.5.10. Хэрлэн гол болон бусад голуудад шаардлагатай гүүрийг шинээр барьж, сэргээн засварлана. | |
| | 3.5.11. Хот хоорондын болон орон нутгийн нийтийн тээвэр, шуудан үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна. | |

| | | |
|---|---|---|
| | 6.1.6. Чингис хотод цэцэрлэгийн барилга-өргөтгөл 2, сургуулийн барилга-өргөтгөл 1, дотуур байрны барилга 2, эрүүл мэндийн төвийн барилга-өргөтгөл 1, спорт заал, талбай 2, соёлын төвийн барилга 1, залуучуудын сургалт, хөгжлийн төв 1, иргэдэд үйлчлэх төрийн байгууллагын барилга 4-ийг тус тус барьж байгуулна. | |
| | 6.2.5. Сургуулийн барилга-өргөтгөл 6, дотуур байрны барилга 5, соёлын төвийн барилга 5, спорт заал, талбай 6, эрүүл мэндийн төвийн барилга-өргөтгөл 6, залуучуудын сургалт, хөгжлийн төв 2, ахмадын байр 1, иргэдэд үйлчлэх төв 10-ийг тус тус барьж байгуулна. | |
| | 6.2.6. Сумын төвийн гэр хорооллын инженерийн, ариутгах татуургын шугам сүлжээ болон цэвэрлэх байгууламж, сум доторхи зам, төмөр бетон модон гүүрийг шинэчлэх, засварлах ажлыг гүйцэтгэнэ. | |
| | 3.5.12. Аялал жуулчлалыг хөгжүүлэх маршрут бүхий сумдад нисэх буудал зориулалттай газрын нөөцийг тогтоож, Чингис хот-Дадал сум-Чингис хот, Чингис хот-Улаанбаатар хот-Чингис хот чиглэлд тогтмол нислэгтэй болгоно. | |
| | 6.1.4. Хэрлэн сумын 1 дүгээр багт хэрэгжиж байгаа гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслийг дуусгана. | |
| | 6.1.7. Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд зочид буудал, худалдааны төв, малын гаралтай түүхий эд болон боловсруулах үйлдвэрүүдийг байгуулж, төвийн болон гэр хорооллын инженерийн шугам сүлжээ, хотын доторх хатуу хучилттай авто зам, ариутгах татуургын шугам сүлжээ, цэвэрлэх байгууламжийн ажлыг гүйцэтгэнэ. | |
| ҮЧҮ-4: Орон нутгийн хөгжлийн санг хуульд заасан эх үүсвэрээс бүрдүүлж, хуулиар хориглосон зүйлд зарцуулахгүй байхад хяналт тавьж, үйл ажиллагааны журмын хэрэгжилтийг хангаж ажиллана. | 6.2.1. Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, сангийн үйл ажиллагааны үр дүнг үнэлж дүгнэх, ил тод байдлыг сайжруулахад иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлнэ. | СЗДТГ |

| | | | |
|---|---|---|---|
| Салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хуулийн тоо | | 12 | |
| Үүнээс: | Тухайн салбарын хуулийн тоо | 3 | |
| | Нийтлэг мөрддөг хуулийн тоо | 9 | |

Ерөнхий чиг үүрэг-2: Аймгийн нутаг дэвсгэрт ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгоход хууль тогтоомжид заасны дагуу санал өгөх, ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар хууль тогтоомжид заасан үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих ажлыг зохион байгуулж, гарсан зөрчлийг таслан зогсоох арга хэмжээ авах. / МУЗЗНДНэгжийн хууль 29.1.3. е, н/

| Үндсэн чиг үүрэг | Дэд чиг үүрэг | Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид |
|---|---|---|
| ҮЧҮ-1: Ашигт малтмалын болон ТТАМ-ын тухай хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газраас гаргасан шийдвэрийн биелэлтийг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах, аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх үйл ажиллагаанд харьялал харгалзахгүйгээр хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах, шаардлагатай бол тухайн аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчинд хортой нөлөөлж буй үйл ажиллагааг өөрөө түдгэлзүүлэн зогсоох буюу уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх; Тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай | 3.2.1. Аймгийн нутаг дэвсгэрт шинээр уул уурхайн лиценз нэмж олголгүй, хяналт мэдээллийг олон нийтэд ил тод болгож, хууль бус зөвшөөрлийг хүчингүй болгуулна. | БОАЖГ, МХГ, ЦГ, СЗДТГ, ХХААГ |
| | 3.2.2. Уул уурхайн компаниудын /"Нийгмийн хариуцлага"-ын хүрээнд/ нийт бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний худалдан авалтын 30-аас доошгүй хувийг орон нутгийн жижиг дунд үйлдвэрлэгч, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгжүүдээс авах ажлын зохион байгуулалтыг хийж эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ. | |
| | 3.2.3. Жоншны баяжмал, шууд ангижруулсан төмрийн үйлдвэрийн төслүүдийг хэрэгжүүлнэ. | |

<table>
<tr><td colspan="2">холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар гэрээ байгуулж ажиллана.</td><td></td><td></td></tr>
<tr><td colspan="2">Салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хуулийн тоо</td><td colspan="2">17</td></tr>
<tr><td rowspan="2">Үүнээс:</td><td>Тухайн салбарын хуулийн тоо</td><td colspan="2">8</td></tr>
<tr><td>Нийтлэг мөрддөг хуулийн тоо</td><td colspan="2">9</td></tr>
<tr><td colspan="4">Ерөнхий чиг үүрэг-3: Нутаг дэвсгэрийнхээ байгалийн баялгийг ашиглах, байгаль орчныг хамгаалах, орчны бохирдлыг бууруулах, цэцэрлэгт хүрээлэн, зүлэгжүүлсэн талбай байгуулах, мод, бут сөөг тарьж ургуулах, газар нутгийнхаа тодорхой хэсгийг орон нутгийн тусгай хамгаалалтад авах, бусад арга хэмжээний цогцолбор хөтөлбөрийг боловсруулж батлуулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах. / МУЗЗНДНэгжийн хууль 29.1.3. б, е, л, н/</td></tr>
<tr><td colspan="2">Үндсэн чиг үүрэг</td><td>Дэд чиг үүрэг</td><td>Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид</td></tr>
<tr><td colspan="2" rowspan="5">ҮЧҮ-1: Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах, нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гарсан шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах;</td><td>5.1.1. Чингис хотын агаар, хөрсний бохирдлыг бууруулах менежментийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлнэ.</td><td rowspan="3">БОАЖГ, СЗДТГ, УЦУОШТ</td></tr>
<tr><td>5.1.2. Шахмал түлшний хэрэглээг нэвтрүүлж, "Эко өрх", “Өрх бүр ногоон төгөл” аяныг хэрэгжүүлж, гэр хорооллын айл өрхүүдийн 50 хүртэл хувийг хамруулснаар агаар, хөрсний бохирдлыг тус тус 30 хүртэл хувиар бууруулна.</td></tr>
<tr><td>5.1.3. Хогны менежментийг үр дүнтэй хэрэгжүүлж, хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах ажлыг иргэд, аж ахуйн нэгжүүдийн дунд хэвшүүлж, дахин боловсруулах боломжтой хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах замаар төвлөрсөн хогийн цэгт очих хог хаягдлын хэмжээг 40 хүртэл хувиар бууруулна.</td></tr>
<tr><td>5.1.4. Төв суурин газрын ногоон байгууламжийн эзлэх талбайн хэмжээг жил бүр нэмэгдүүлж, нийт 65 га-д хүргэнэ.</td><td rowspan="2">БОАЖГ, СЗДТГ<br>Ойн ангиуд</td></tr>
<tr><td>5.1.5. Аймгийн хэмжээнд 1000 га талбайд ойжуулалт, байгалийн сэргэн ургалтад туслах ажлыг хийж, нийт ойн сангийн ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг 0.05 хувиар нэмэгдүүлнэ.</td></tr>
</table>

| | | |
|---|---|---|
| | 5.1.6. Цэнгэг усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эх, түүний ай сав газар, ховор ан амьтан ургамлын тархац нөөц бүхий байгалийн унаган төрхийг хадгалж хамгаалах, экосистемийн ач холбогдол бүхий газруудыг улсын болон аймаг, орон нутгийн тусгай хамгаалалтад авах ажлыг зохион байгуулж, нийт нутаг дэвсгэрийн 47 хувьд хүргэнэ. | БОАЖГ, СЗДТГ, Аймаг сумын ИТХ |
| | 5.1.7. Амьтны нөөцийг хамгаалах, өсгөж үржүүлэх, зохистой ашиглах менежмент зохион байгуулалтыг хийж, ховор амьтдын тоо толгойг 3 хүртэл хувиар өсгөнө. | БОАЖГ, СЗДТГ |
| | 5.1.8. Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийн хэрэгжилтийг хангаж, 80-аас доошгүй булаг, шандны эхийг хашиж хамгаална. | БОАЖГ, СЗДТГ |
| | 5.1.9. Элэгдэл, эвдрэлд орж эзэнгүй орхигдсон газар, түүний хэвлийд техникийн нөхөн сэргээлтийг 80 га газарт хийнэ. | БОАЖГ, СЗДТГ |
| Салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хуулийн тоо | | 16 |
| Үүнээс | Тухайн салбарын хуулийн тоо | 7 |
| | Нийтлэг мөрддөг хуулийн тоо | 9 |
| Ерөнхий чиг үүрэг-4: Төрийн бодлого, хууль тогтоомж, Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх үндсэн дээр хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах, мал сүргийг өсгөн үржүүлэх, малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах, мал эмнэлэг, үржлийн ажлыг зохион байгуулах, байгалийн гэнэтийн аюул, мал, амьтан, ургамлын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх, газар тариалангийн болон жижиг, дунд, хөнгөн үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг боловсруулж Хуралд өргөн мэдүүлэх, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулна. / МУЗЗНДНэгжийн хууль 29.1.3. а, б/ | | |
| Үндсэн чиг үүрэг | Дэд чиг үүрэг | Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид |
| ҮЧҮ-1: Үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэний тариалалтыг дэмжих, тариалангийн бүс нутгийг тогтоох, тариалангийн газрыг зүй зохистой ашиглах, хөрсийг хамгаалах, сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлж, газар тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ. | 3.3.1. Тариалангийн талбайн ашиглалтыг сайжруулан эргэлтэд оруулж, хөрсний үржил шимийг хамгаалах, хашаажуулах, сэлгээнд үр тарианы тариалалтыг нэмэгдүүлэх замаар тариалангийн тогтвортой хөгжлийг хангана. | ХХААГ, ГХБХБГ, Төсөл хөтөлбөрүүд |
| | 3.3.2. Төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлийг механикжуулж, усалгаатай тариалангийн талбайг нэмэгдүүлэн, хүлэмж, зоорийн аж ахуйн хангамжийг сайжруулна. | |

| | | |
|---|---|---|
| ҮЧҮ-2: Аймгийн нутаг дэвсгэрт мал аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, малын генетик нөөцийг тогтвортой ашиглах, хамгаалах, сайжруулах үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх, мал, амьтны гаралтай хүнсний болон хүнсний бус түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэврийн үзлэг, лабораторийн шинжилгээ, мал эмнэлгийн үйл ажиллагааг зохион байгуулж, хяналт тавих. | 3.3.3. Малын тоог чанарт шилжүүлэх, ашиг шимийг нэмэгдүүлэх, эрчимжсэн мал аж ахуйг дэмжиж, "Монгол мал-II" арга хэмжээг хэрэгжүүлнэ. | ХХААГ, Төсөл хөтөлбөрүүд |
| | 3.3.4. Мал эмнэлгийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, оношилгоо шинжилгээний чадавхийг нэмэгдүүлэн малын гаралтай халдварт, гоц халдварт өвчний гаралтыг бууруулна. | ХХААГ, Төсөл хөтөлбөрүүд |
| ҮЧҮ-3: Мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх, өвчингүй, тайван улс, бүс, нутаг, хот айл, аж ахуйн нэгжийг тогтоон баталгаажуулах үйл ажиллагаа, мал, амьтны гаралтай хүнсний болон хүнсний бус түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэврийн үзлэг, лабораторийн шинжилгээ, мал эмнэлэг, хорио цээр, хязгаарлалтын хяналт, шалгалттай холбогдох харилцаанд үйлчилнэ.<br>/Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 3.1/ | 3.3.5. Бэлчээр хамгаалалт, ашиглалтыг сайжруулан, өвс тэжээлийн нөөц бүрдүүлэлт, усан хангамжийг нэмэгдүүлнэ. | МЭГ, Төсөл хөтөлбөрүүд |
| ҮЧҮ-3: Орон нутагт жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг төрөлжүүлэн хөгжүүлж, өрсөлдөх чадварыг сайжруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх, тэдгээрийн эдийн засагт эзлэх хувь оролцоог дээшлүүлнэ. | 3.3.6. Гарааны бизнес эрхлэгчид, импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэгч хувийн хэвшлийн санал санаачилгыг хөнгөлөлттэй зээлийн бодлогоор дэмжиж, борлуулалтын сүлжээг нэмэгдүүлнэ. | ХХААГ, Төсөл хөтөлбөрүүд |
| | 6.2.2. Төр, хувийн хэвшлийн дэмжлэгээр сумдын халуун усны болон нийтийн ахуйн үйлчилгээг сайжруулна. | |
| Салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хуулийн тоо | 11 | |

<table>
<tr><td></td><td>Тухайн салбарын хуулийн тоо</td><td colspan="2">2</td></tr>
<tr><td></td><td>Нийтлэг мөрддөг хуулийн тоо</td><td colspan="2">9</td></tr>
<tr><td colspan="4">Ерөнхий чиг үүрэг-5: Нутаг дэвсгэртээ аялал жуулчлалын талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, тухайн Хурлын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулж, аялал жуулчлалыг хөгжүүлэх.</td></tr>
<tr><td colspan="2">Үндсэн чиг үүрэг:</td><td>Дэд чиг үүрэг</td><td>Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид</td></tr>
<tr><td colspan="2" rowspan="6">ҮЧҮ-1: Аялал жуулчлалын талаар төрөөс баримтлах нэгдсэн бодлогыг нутаг дэвсгэртээ хэрэгжүүлж, аялал жуулчлалын тухай хууль тогтоомжийн биелэлтийг хангах, зохион байгуулах, аялал жуулчлалыг бүсчлэн хөгжүүлэх бодлоготой уялдуулан хөтөлбөр, төсөл боловсруулж, зохих шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд санал оруулах, батлагдсан хөтөлбөрийн дагуу аялал жуулчлал хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх;</td><td>3.4.1. Түүхэн аялал жуулчлалыг хөгжүүлэх маршрутын дагуух сумдад байгаль орчинд ээлтэй, нутгийн иргэд /өрх/-ийг түшиглэсэн тогтвортой, эко аялал жуулчлалын үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн тоог 10 хувиар нэмэгдүүлнэ.</td><td rowspan="6">БОАЖГ, ГХБХБГ, ХХААГ, Төсөл хөтөлбөрүүд</td></tr>
<tr><td>3.4.2. Аялал жуулчлалын салбарын эдийн засгийн чадавх, орлогыг нэмэгдүүлж, ажлын байрыг 30 хувиар нэмэгдүүлнэ.</td></tr>
<tr><td>3.4.3. Түүхэн аялал жуулчлалыг хөгжүүлэх ажлын хүрээнд “Мянганы суут хүн Чингис хаан” цогцолборуудын ажлыг /Дадал сум “Чингис хаан”, Биндэр сум “Их Хуралдай”, Батноров сум “Хүлэг Боорчи-Андлалын өргөө”, Норовлин сум "Шихихутаг-Их засаг”, Бэрх тосгон “Монголын далд уурхайн музей, сургалт, судалгаа, аялал жуулчлалын төв”, Дэлгэрхаан сум “Монголын нууц товчоо”/ дуусгаж, дэд бүтцээр холбох ажлыг эхлүүлнэ.</td></tr>
<tr><td>3.4.4. Түүхэн аялал жуулчлалыг хөгжүүлэх маршрутын дагуу түр буудаллах цэг, мэдээлэл, үйлчилгээний төвийг байгуулж, эдийн засгийн эргэлтэд оруулна.</td></tr>
<tr><td>3.4.5. "Монгол хатад", "Ёохор наадаан", "Чингис фестиваль", "Тогорууны баяр", "Талын түмэн адуу", "Галшар адууны баяр", "Талын тайга нохой" наадам зэрэг эвент арга хэмжээнүүдийн цар хүрээг өргөжүүлэн тогтмол зохион байгуулж, гадаад, дотоодын жуулчдын тоог нэмэгдүүлнэ.</td></tr>
<tr><td>3.4.6. Аялал жуулчлалын салбарт технологийн дэвшил, цахим орчныг ашиглан дотоод, гадаад сурталчилгааг өргөжүүлнэ.</td></tr>
</table>

| | | | |
|---|---|---|---|
| | | 3.4.7. Аялал жуулчлалын салбарын хүний нөөцийг чадваржуулах, үйлчилгээний байгууллагуудын чанар, стандартыг сайжруулах сургалт, зөвлөгөөнийг төр хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан жил бүр зохион байгуулж, зочид буудлуудын зэрэглэлийг 1 шатаар ахиулна. | |
| | | 3.4.8. Түүх, соёлын өв, байгалийн дурсгалт болон өвөрмөц тогтоц бүхий газрууд, орон нутгийн онцлогт тохируулан аялагч, амрагч, жуулчдыг татах төрөлжсөн аялал жуулчлалын бүтээгдэхүүн /морин аялал, завь, агнуур, дугуйн, цанын, уулын спорт г.м/-ийг бий болгож, хөгжүүлнэ. | |
| **ЗАСАГЛАЛЫН ЧИГЛЭЛЭЭР** | | | |
| Салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хуулийн тоо | | 17 | |
| үүнээс | Тухайн салбарын хуулийн тоо | 8 | |
| | Нийтлэг мөрддөг хуулийн тоо | 9 /Монгол Улсын засаг, захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн албан хаагчийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд иргүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль/ | |
| Ерөнхий чиг үүрэг-1: Нутгийн захиргааны байгууллагын манлайллыг хэрэгжүүлж боловсон хүчний бодлогыг тодорхойлох тэдгээрийг сургах давтан сургах, төрийн үйлчилгээний чанар, төрийн албан хаагчийн сахилга хариуцлагыг сайжруулах, иргэдийн өргөдөл гомдлыг шийдвэрлэх хууль тогтоомжийн биелэлтийг тооцон дүгнэх. | | | |
| Үндсэн чиг үүрэг | | Дэд чиг үүрэг | Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид |
| ҮЧҮ-1: Төрийн байгууллага, төрийн албан хаагч хоорондын харилцах дотоод үйл ажиллагааг оновчтой зохион байгуулж, иргэд төрийн үйлчилгээг шуурхай чирэгдэлгүй авах нөхцлийг бүрдүүлэх. | | Дотоод удирдлагын нэгдсэн систем www.erp.e-mongolia.mn-ийг төрийн байгууллагуудад нэвтрүүлэх баг байгуулж тус багаар дамжуулан холбох ажлыг зохион байгуулна. | erp.e-mongolia.mn системийг төрийн байгууллагад нэвтрүүлэх баг187 төрийн байгууллага |

| | | |
|---|---|---|
| | Дотоод удирдлагын нэгдсэн систем www.erp.e-mongolia.mn-ийг нэвтрүүлсэн төрийн байгууллагуудын албан хаагчдын хэрэглээг тогтмолжуулах хяналт тавих ажлыг зохион байгуулна. | erp.e-mongolia.mn системийг төрийн байгууллагад нэвтрүүлэх баг 187 төрийн байгууллага |
| | "E-MONGOLIA" системийн ач холбогдлыг цахимаар болон олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, төрийн байгууллагуудаар дамжуулан иргэд олон нийтэд сурталчлан таниулна. | ГХБХБГ, НДХ, УБХ, ТХ, ЭМД, ХХҮГ, АТТ, ШШГГ, erp.e-mongolia.mn системийг төрийн байгууллагад нэвтрүүлэх баг, Хэвлэл мэдээллийн байгууллагууд |
| | Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа 187 төрийн байгууллагын 4500 төрийн албан хаагчид болон 120 чиглүүлэгч 791 аравт, хэсгийн ахлагч нарт E-MONGOLIA системийг танилцуулах сургалт зохион байгуулж, ашиглаж хэвшүүлэх ажлыг зохион байгуулна. | Систем нэвтрүүлэх баг, төрийн байгууллагууд |
| ҮЧҮ-2:<br>Нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг болон иргэн, хуулийн этгээдийн мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангах. | Хэнтий.мн сайтад 18 сумын төрийн байгууллагуудыг холбож үйл ажиллагаа, хүний нөөц, төсөв санхүү, худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангана. | Тендерт шалгарсан компани |
| | Төвийн болон орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулж нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангана. | Гэрээ байгуулсан хэвлэл мэдээллийн байгууллагууд |
| | Иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж төрийн байгууллагын ил тод байдлыг хангах "Иргэдийн оролцоот-Хэтийн Хэнтий" арга хэмжээг хэрэгжүүлнэ. | Тогтвортой амжиргаа 3 төсөл |

| | | |
|---|---|---|
| ҮЧҮ-8: Төрийн албан хаагчдын харилцаа хандлагыг өөрчилж, төрийн үйлчилгээний чанар, төрийн албан хаагчдын сахилга хариуцлагыг дээшлүүлэх. | Авилгатэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аймаг орон нутгийн онцлогт тохируулан жил бүр боловсруулан "Эрх бүхий албан хаагчдын баг"-аар дамжуулан хэрэгжилтийг зохион байгуулна. | Эрх бүхий албан тушаалтны баг |
| ҮЧҮ-9: | Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа 178 төрийн байгууллагуудад Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд заасан шаардлагын дагуу үйлчилгээний стандартыг нэвтрүүлнэ | СХЗХ178 төрийн байгууллага |
| | Сумдын Засаг даргын Тамгын газар, Хот, тосгоны захирагчийн ажлын алба, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, Улсын бүртгэлийн хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс, Татварын хэлтэс, Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, аймгийн Нэгдсэн эмнэлэг, Архивын тасаг зэрэг иргэдэд төрийн үйлчилгээг шууд хүргэдэг байгууллагуудын албан хаагч нарын үйл ажиллагааг иргэн үнэлдэг төхөөрөмж, дуу, дүрсний хяналтын системийг нэвтрүүлнэ. | ГХБХГ, УБХ, НДХ, ЭМДХ, ТХ, ХХҮГ, АТТ, аймгийн Нэгдсэн эмнэлэг, СЗДТГ, Төрийн байгууллагууд |
| | Төрийн Улс төрийн, төрийн захиргааны, төрийн үйлчилгээний албаны удирдах болон гүйцэтгэх албан хаагч нартай хариуцлагын гэрээ байгуулж төрийн албан хаагчийн хяналтын хуудсыг нэвтрүүлж сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн мэдээллийг олон нийтэд улирал тутам мэдээлнэ. | Төрийн байгууллагууд |
| | Төрийн албан хаагчдын хэрэгцээ, шаардлагад үндэслэн "Танхимын болон цахим сургалт"-ын нэгдсэн арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж тухай бүр түвшинг тогтооно. | Төрийн байгууллагууд |
| ҮЧҮ-13: Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон аж ахуй нэгж байгууллагуудыг | ОХУ болон БНХАУ-ын хамтын ажиллагаатай муж, хотууд, гуравдагч орны боловсрол, соёл урлаг, спорт, хөдөө аж ахуй, худалдаа, байгаль орчин, аялал жуулчлал зэрэг салбарт төрийн болон аж ахуй нэгж байгууллага, бизнес эрхлэгчдийг | ХАҮТ, Төрийн болон аж ахуй нэгж байгууллага, бизнес эрхлэгчид |

<table>
<tr><td colspan="2">хамтын ажиллагаатай улс орны муж, хоттой хамтран ажиллах боломжийг бүрдүүлнэ.</td><td>хамтран ажиллахад дэмжлэг үзүүлж, туршлага судлах боломжоор хангана</td><td></td></tr>
<tr><td colspan="4">Батлан хамгаалах чиглэлээр</td></tr>
<tr><td colspan="2">Салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хуулийн тоо</td><td colspan="2">11</td></tr>
<tr><td rowspan="2">үүнээс</td><td>Тухайн салбарын хуулийн тоо</td><td colspan="2">2</td></tr>
<tr><td>Нийтлэг мөрддөг хуулийн тоо</td><td colspan="2">9</td></tr>
<tr><td colspan="4">Ерөнхий чиг үүрэг-1: Гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдсон үед айл өрх, хүн, малыг нүүлгэн шилжүүлэх, тэдгээрийг зохих үйлчилгээгээр хангах ажлыг зохион байгуулах, хүн хүч, тээвэр, холбооны хэрэгсэл, эд хөрөнгийг дайчлах ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах</td></tr>
<tr><td colspan="2">Үндсэн чиг үүрэг</td><td>Дэд чиг үүрэг</td><td>Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид</td></tr>
<tr><td colspan="2" rowspan="3">ҮЧҮ-1: Гамшгаас хамгаалах сургалт нь төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд албан тушаалтан, ажилтан болон иргэнийг сурган дадлагажуулж, үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийн эх үүсвэр, гамшгаас хамгаалах болон орон нутгийн нөөцийг бүрдүүлэх, түүнийг захиран зарцуулах<br>/Гамшгаас хамгаалах тухай хууль 32.1.3. 13.1./</td><td>1.3.11. Сумдад гамшгаас хамгаалах иж бүрэн, команд штабын сургууль, удирдах ажилтны сургалт, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх үзлэгийг жил бүр зохион байгуулж гамшгаас хамгаалах төрийн үйлчилгээг шуурхай хүргэнэ.</td><td rowspan="3">Онцгой байдлын газар, аймаг, сумдын ЗДТГ, агентлаг байгууллагын удирдлагууд</td></tr>
<tr><td>1.3.12.Гамшиг ослын үед ажиллах туулах чадвартай автомашин, техник, тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлнэ.</td></tr>
<tr><td>1.3.13. Гамшгийн аюулын үед харилцан ажиллах дадлага, харилцаа холбоог сайжруулах, иргэдэд гамшиг аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх мэдээ мэдээллийг шуурхай хүргэх нөхцөлийг бүрдүүлнэ.</td></tr>
<tr><td colspan="2">Салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хуулийн тоо</td><td colspan="2">15</td></tr>
<tr><td rowspan="2">үүнээс</td><td>Тухайн салбарын хуулийн тоо</td><td colspan="2">6</td></tr>
<tr><td>Нийтлэг мөрддөг хуулийн тоо</td><td colspan="2">9</td></tr>
</table>

<table>
<tr><td colspan="3">Ерөнхий чиг үүрэг-2:<br>Нутаг дэвсгэртээ батлан хамгаалах, цэргийн анги, салбар, улсын аюулгүй байдлыг хангаж ажиллах;</td></tr>
<tr><td>Үндсэн чиг үүрэг</td><td>Дэд чиг үүрэг</td><td>Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид</td></tr>
<tr><td rowspan="5">ҮЧҮ-1: Батлан хамгаалах хууль тогтоомжийг хэрэгжүүлж, орон нутгийн хамгаалалтыг төлөвлөн, дайчилгааны бэлтгэл нөөцийн сургалтыг зохион байгуулж, иргэд, хүүхэд залуучуудад эх оронч үзэл, хүмүүжил, үндэсний бахархал, уламжлалыг төлөвлшүүлж, боловсол, оюун санаа, бие бялдарыг хөгжүүлэхэд оршино.<br>/Батлан хамгаалах тухай хууль 17 дугаар зүйл, Орон нутгийн хамгаалалтын тухай хуулийн 19 дүгээр зүйл, Дайчилгааны тухай хуулийн 5 дугаар бүлэг,</td><td>1.3.14. Хугацаат цэргийн алба хаасан иргэдийг сурч боловсрох, ажлын байранд зуучлах, төрийн албанд орох, нийгмийн суурь судалгаанд хамруулан халамжид хамрагдахад дэмжлэг үзүүлнэ.</td><td rowspan="5">Хөдөлмөр, халамжийн, үйлчилгээний газар, Эрүүл мэндийн газар, Боловсрол соёлын газар, Сумдын Засаг даргын Тамгын газар</td></tr>
<tr><td>1.3.15. Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөний дагуу нөөц бүрдүүлэх, сэдэвчилсэн сургалт зохион байгуулна.</td></tr>
<tr><td>1.3.16. Улсын болон цэргийн дайчилгааны төлөвлөгөөний дагуу албан байгууллага, иргэдийг даалгаваржуулж, тогтоосон хугацаанд тодотголыг явуулна.</td></tr>
<tr><td>1.3.17. Цэргийн бүртгэлийн цахим системийг нэвтрүүлж, сумдыг холбоно.</td></tr>
<tr><td>1.3.18. “Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвлшүүлэх” арга хэмжээг хэрэгжүүлж аймгийн Политехник коллежид “Оюутан-Цэрэг” сургалтыг зохион байгуулна.</td></tr>
</table>

## ГУРАВ. АЛСЫН ХАРАА

Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газар нь Төрийн үйлчилгээг иргэн бүрт хүргэгч нутгийн захиргааны төлөвшсөн байгууллага болно.

## ДӨРӨВ. ЭРХЭМ ЗОРИЛГО

Иргэдэд ойр, тэдний хэрэгцээг хангахад чиглэсэн, өөрчлөгдөн буй орчинд уян хатан зохицож чаддаг бөгөөд идэвхитэй, санаачлагатай, манлайлагч менежер бүхий цомхон, чадварлаг, эцсийн үр дүнг эрхэмлэн дээдэлсэн, төрийн албыг төлөвшүүлэхэд оршино.

## ТАВ. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

| Боловсрол |
| --- |
| Хүн бүрт сурах таатай орчинг бүрдүүлж, сургалтын чанарыг дээшлүүлнэ |

<table>
<tr><th colspan="2">Дотоод орчин</th></tr>
<tr><th>Давуу тал</th><th>Сул тал</th></tr>
<tr><td>
<ul>
<li>Сүүлийн 4 жилд боловсролын чиглэлээр хийсэн хөрөнгө оруулалт нэмэгдсэн.</li>
<li>“Хүүхэд хөгжил хөтөлбөр” хэрэгжиснээр СӨБ-ын сургалтын орчин сайжирсан.</li>
<li>ЭЕШ-ын дундаж оноо 28 хувиар ахисан.</li>
<li>Монгол улсын хэмжээнд 2 ясли байдгийн 1 нь Хэнтий аймагт байна.</li>
<li>Багш нарыг урамшуулах журам хэрэгжиж, жил бүр Засаг даргын нэрэмжит шагнал, ЭЕШ-ын онооны үнэлгээг харгалзан шагнаж урамшуулж хэвшсэн.</li>
<li>Орон нутагт шаардлагатай мэргэжлээр суралцах оюутан, залуучуудад зориулсан “Сургалтын төлбөрийн журам” хэрэгжиж байна.</li>
</ul>
</td><td>
<ul>
<li>СӨБ-ын мэргэжлийн багшийн хангалт 95, ЕБС 96 хувьтай байна.</li>
<li>ЕБС-ийн сургалтын орчин хангалтгүй.</li>
<li>Математик сургалт 9 болон 12 ангийн сургалтын чанар 32.45%, байгалийн ухааны сургалтын чанар 34.1% -тай байна.Энэ нь сургуулийн хэв шинж, багш нарын хүрэлцээ, чадвартай холбоотой харагдаж байна.</li>
<li>Байгалийн ухааны хичээлийн багш, дуу хөгжмийн багш, СӨБ багш дутагдалтай.</li>
<li>1-2 насны хүүхдүүд яслид хамрагдах боломж муу байна.</li>
<li>БСУГазарт багш нарыг сургах байр танхим, техник тоног төхөөрөмжийн хүрэлцээ хангамж муу байна.</li>
<li>Багш нарыг чадваржуулах, давтан сургах, хөгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ хэрэгжихгүй байна.</li>
<li>Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцах орчин бүрдээгүй.</li>
<li>Цахим туршилтыг бусад сургуулиудад хэрэгжүүлэхэд хангалттай компьютер байхгүй байна. Аймгийн хэмжээнд 1 компьютерт ногдох хүүхдийн тоо 18 байна.</li>
<li>НТБТөвийн багш нарын мэдлэг чадвар, арга зүй</li>
<li>Сургуулиадад цахим сургалтыг турших компьютер тоног төхөөрөмжийн төсөв, хөрөнгө бүрдээгүй.</li>
</ul>
</td></tr>
<tr><th colspan="2">Гадаад орчин</th></tr>
<tr><th>Боломж</th><th>Эрсдэл</th></tr>
<tr><td>
<ul>
<li>БШУЯ-аас нүхэн жорлонг бүрэн өөрчлөх хөтөлбөр хэрэгжүүлж эхэлж байна.</li>
<li>БШУЯ-аас цэцэрлэгүүдэд яслийн бүлэг нээж, 1-2 настай хүүхдүүдийг СӨБ-д хамруулах боломжтой</li>
<li>БШУЯ-аас “Чадварлаг багш” хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлж байна.</li>
<li>“Тогтвортой хөгжлийн боловсрол” төсөл 5 аймагт хэрэгжиж байгаагийн 1 нь Хэнтий аймаг байна.</li>
</ul>
</td><td>
<ul>
<li>НТБТ-өөс цахимаар зохион байгуулж байгаа сургалтад иргэд хамрагдахгүй байх</li>
<li>Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч 120 аж ахуйн нэгж байгаа ч үйл ажиллагаа эрхэлдэг бөгөөд бүгд орон нутагт санхүүгийн дэмжлэг үзүүлэх чадвартай эсэх</li>
</ul>
</td></tr>
</table>

<table>
<tr><td><ul><li>БШУЯ-аас боловсролын салбарын үйл ажиллагааг цахимжуулах зорилгоор Хэрлэн 1, Биндэр сумын сургуулиудад цахим сургалтыг турших байна. Бусад сургуулиудад турших хүсэлтэй байна.</li><li>Цар тахлын үед иргэн бүр фэйсбүүкийн хэрэглэгч болсон тул насан туршийн боловсролыг иргэдэд цахимаар хүргэх боломжтой.</li><li>Аймгийн нутаг дэвсгэрт ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуй нэгж байгууллага 120 байгаа бөгөөд тэдний 22 нь тогтмол үйл ажиллагаа явуулж байна.</li></ul></td><td><ul><li>Ковид-19 цар тахлын улмаас хичээл сургалтын үйл ажиллагаа тасалдах, арга хэмжээ зохион байгуулах, үр дүнг үнэлэх боломжгүй болох</li><li>2 жилийн хугацаанд цар тахлын улмаас хичээл сургалтын цахимаар орсон тул сургалтын чанарт сөргөөр нөлөөлөх</li></ul></td></tr>
<tr><td colspan="2">Хөдөлмөр, нийгмийн хамгаалал</td></tr>
<tr><td colspan="2">Нийгмийн хамгааллыг оновчтой хүртээж, хүн амын хөгжлийг хангаан хөдөлмөр эрхлэлтийн түвшинг 5-аас дээш хувиар нэмэгдүүлнэ.</td></tr>
<tr><td colspan="2">Дотоод орчин</td></tr>
<tr><td>Давуу тал<ul><li>2019 онд аймгийн Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлэлтийн судалгаа хийгдсэн.</li><li>Аймгийн дахь ПТК-д эрэлттэй мэргэжлээр анги нээх боломжтой</li></ul></td><td>Сул тал<ul><li>Төрийн байгууллагуудад Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь заалтын хэрэгжилт хангалтгүй байдаг.</li><li>Туслах малчины эрх зүйн орчин бүрдээгүй</li></ul></td></tr>
<tr><td colspan="2">Гадаад орчин</td></tr>
</table>

| Боломж | Эрсдэл |
|---|---|
| • ХНХЯ-наас халамжаас-хөдөлмөрт шилжих бодлого барьж байгаа бөгөөд өрхийн амьжиргааны судалгааг өөрчилж байгаа<br>• Ирэх 4 жилд бүтээн байгуулалтын томоохон ажлууд хийгдэж байгаа / Дулааны цахилгаан станц, Төв цэвэрлэх байгууламж, Өндөрхаан нисэх буудал, Мянганы суут хүн Их Эзэн Чингис хаан, Их хуралдайн орд өргөө, Андлалын өргөө/<br>• Хөдөлмөр, эрхлэлтийг дэмжих сангаас 6 төсөл хөтөлбөр, 1 жижиг зээл олгодог. | • Ковид-19 цар тахлын улмаас бүх нийтийн хөл хорио тогтоох<br>•<br>• |
| Хүүхэд, залуучууд, ахмад настан, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй зэрэг хүн ам зүйн чиглэлээр явуулах бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэн хэрэгжилтийг хангах | |
| Дотоод орчин | |
| Давуу тал | Сул тал |
| • Хохирогч хамгаалах байр, НЦҮТ-тэй<br>• Залуучуудын оролцоог хангах зорилгоор сайн дурын залуучуудыг бүртгэх, ажилд оролцуулах эхлэл тавигдаж байгаа бөгөөд Хэрлэн суманд 35 залуучуудыг сайн дурын ажилтнаар бүртгээд байна.<br>• Ахмадын ордонтой<br>• Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 5 ТББ байдаг.<br>• Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар зөвлөл ажилладаг | • Хүүхдэд ээлтэй байдлын индекс 4<br>• 18-25 насны залуучуудын ажилгүйдэл өндөр<br>• Ахмадын сантай байгууллага цөөхөн<br>• Жендэрийн чиглэлээрх хүн амын ойлголт, хандлага бага<br>• Жендэрийн эрх, тэгш байдлыг хангах чиглэлээр санхүүжилт хангалтгүй. |
| Гадаад орчин | |
| Боломж | Эрсдэл |
| • Хүүхэд, залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах чиглэлээр тус бүр үндэсний хөтөлбөрүүд хэрэгжиж байгаа<br>• Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр төсөл, хөтөлбөрүүд зарлагддаг. | • Ковид-19 цар тахлын улмаас бүх нийтийн хөл хорио тогтоох<br>• Ажилгүйдэл, архидалт |

<table>
<tr><th colspan="2">Соёлын чиглэлээр</th></tr>
<tr><td colspan="2">Соён гэгээрүүлэх үйл ажиллагааг идэвхжүүлж, үндэсний агуулгатай соёлын бүтээлийг дэмжин соёл, урлагийн байгууллагын өрсөлдөх чадвар, эдийн засаг, нийгмийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ.</td></tr>
<tr><td colspan="2">Дотоод орчин</td></tr>
<tr><td>Давуу тал<br>• Хөрш орны соёлын харилцаа нэмэгдэж уран бүтээлчид харилцан туршлага солилцох хамтран ажиллах боломж бүрдсэн<br>• Соёл урлагийн байгууллагын барилга байгууламж шинэчлэгдэж ажиллах орчин эрс дээшилсэн.<br>• Материаллаг баазаа бэхжүүлж хөгжим техник хэрэгсэл тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан<br>• Соёл урлагийн эвент арга хэмжээ<br>- Чингис фистиваль<br>- Алтаргана наадам<br>- Талын түмэн адуу<br>- Тогорууны баяр<br>- Галшар үүлдрийн адуу<br>- Монгол тайга нохойны үзэсгэлэн зэрэг арга хэмжээнүүд</td><td>Сул тал<br>• Хөдөө орон нутагт соёл урлагийн мэргэжлийн боловсон хүчин хангалтгүй<br>• Соёл урлагийн чиглэлээр сурч боловсрох иргэдийн тоо цөөн<br>• Мэргэжлийн хөгжмийн багш, орон нутаг судлах танхим, бужгийн багш дутагдалтай.<br>• Соёлын төвүүдийн барилга байгууламж муу, стандартын бус чанар хангахгүй засвар хийх шаардлагатай.<br>• Соёлын ажилтны цалин хангамж нийгмийн баталгаа муу нэмэгдэл урамшил байхгүй<br>• Соёл урлагийн ажилтнуудын цалин бусад төрийн үйлчилгээний албан хаагчдын цалинтай харьцуулахад бага, мэргэжил дээшлүүлэх, мэргэшүүлэх үйл ажиллагааны зардал бага, цалингийн сүлжээний хувь хэмжээ доогуур, төрөл бүрийн нийгмийн халамж үйлчилгээнд хамрагддаггүй</td></tr>
<tr><td colspan="2">Гадаад орчин</td></tr>
<tr><td>Боломж<br>• Хэнтий аймгийг түүхэн аялал жуулчлалын бүс нутаг болгосон.<br>• Аялал жуулчлал хөгжүүлж гадаад харилцааг бэхжүүлэх нөхцөл боломж бүрдсэн.<br>• Хорио цээр цар тахлын үед соёл урлагийн байгууллагууд дотооддоо ажилчдынхаа ур чавдарыг дээшлүүлэх, ажлын байрны орчин нөцлийг сайжруулах</td><td>Эрсдэл<br>• Ковид-19 цар тахлаас шалтгаалан соёл урлагийн үйл ажиллагаа зогсонги болж иргэдэд хүргэх амьд харилцаа алдагдах эрсдэлтэй<br>• Төрийн захиргааны дээд байгууллагын удирдлага зохион байгуулалт<br>• Иргэдийн оролцоо тутмаг</td></tr>
<tr><th colspan="2">Спортын чиглэлээр</th></tr>
</table>

| Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх эрүүл идэвхтэй амьдрах дадал олгох нийтийн биеийн тамирыг хөгжүүлж, спортын салбарт амжилт гаргаж, уралдаан тэмцээнд амжилттай оролцсон баг, тамирчдыг дэмжинэ. | |
|---|---|
| Дотоод орчин | |
| Давуу тал | Сул тал |
| • Сүүлийн 4 жилд спортын чиглэлээр хөрөнгө оруулалт нэмэгдсэн.<br>• Төсөв санхүү боломжийн, хангалттай.<br>• Материаллаг бааз сайжирсан.<br>• Спортын заал танхим , гадаа талбай хангалттай | • Боловсон хүчний хангалт муу, мэргэжлийн боловсон хүчин шаардлагатай.<br>• Биеийн тамирийн багш дасгалжуулагчдын мэргэжил боловсролын дээшлүүлэх давтан сургалт дутагдалтай.<br>• Орчин үеийн техник тоног төхөөрөмж авах<br>• Спортын барилга байгууламж муу, стандартын бус чанар хангахгүй засвар хийх шаардлагатай. |
| Гадаад орчин | |
| Боломж | Эрсдэл |
| • Төрийн болон төрийн бус байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах боломж байгаа, боловч дутагдалтай.<br>• Улс аймгийн уралдаан тэмцээнд амжилт гаргах боломжтой | • Ковид-19-ын халдвар гарах эрсдэл өндөр<br>• Болзошгүй Гамшиг тохиолдсон нөхцөлд сул зогсолт, эрсдэлтэй<br>• Иргэдийн оролцоо тутмаг |

**Эрүүл мэнд**

| Дотоод орчин | |
|---|---|
| Давуу тал | Сул тал |
| • Сүрьеэгийн шинэ эмнэлэг ашиглалтад орсон.<br>• Зүүн бүсийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй Зооноз өвчин судлалын төвтэй.<br>• Уламжлалт анагаах ухааны эмнэлэгтэй.<br>• Бэлтгэгдсэн андрологи эмчтэй.<br>• Хүүхдийн эмчийг сум бүрд бэлтгэх бодлогыг хэрэгжүүлснээр 12 суманд хүүхдийн эмч ажилладаг. | • Эмнэлгийн тоног төхөөрөмжийн дутагдал, эвдрэл их.<br>• Хүн амын өвчлөл жил бүр нэмэгдэж байна.<br>• Хавдрын өвчлөл, тэр дундаа элэгний хавдрын өвчлөлөөр 2020 оны байдлаар улсын хэмжээнд 1-рт орж байна.<br>• Эрчүүдийн нас баралт, өвчлөл өндөр<br>• БЗДХ, сүрьеэгийн өвчлөлийн тархалт буурахгүй байна.<br>• Зайлшгүй шаардлагатай зарим мэргэжлийн эмч, эмнэлгийн ажилчид дутмаг /клиникпарматлоги, эмч зүйч, сувилагч, хавьтал судлагч, хүүхдийн эмч, дотоод шүүрлийн эмч/<br>• Эмч, эмнэлгийн ажилчдын ёс зүй, харилцаа хандлагатай холбоотой гомдол их гардаг.<br>• Суурь өвчтэй хүүхэд төрөх, хүүхдийн өвчлөл их байна. |

| Гадаад орчин | |
|---|---|
| Боломж | Эрсдэл |
| • Ковид-19 халдварын бэлэн байдлыг хангах зорилгоор нэн шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах, дэмжлэг үзүүлэх<br>• Ковид-19-оос сэргийлэх зорилгоор хувийн ариун цэврийг сахих, маск зүүх зан үйлийг хэвшүүлж байгаа нь халдварт өвчний тархалтыг бууруулж байна.<br>• Аймгийн Нэгдсэн эмнэлэгт цахим үйлчилгээг нэвтрүүлж байна.<br>• Сувилагч мэргэжлээс суралцагчдын төлбөрийг төрөөс хариуцдаг.<br>• Төрийн сангаас нарийн мэргэжлийн эмч нарыг үнэ төлбөргүй сургадаг.<br>• Нарийн мэргэжлийн салбар бүрээр нийгэмлэгүүд байгуулагдсан. | • Ковид-19-ын халдвар гарах эрсдэл өндөр.<br>• Хүн амын өвчлөл нэмэгдэхийн хэрээр эмнэлэгт ачаалал үүсэх нь алдаа гарах эрсдэлийг нэмэгдүүлж байна.<br>• Орон нутагт тухайн нэг чиглэлээр бэлтгэгдсэн эмч, эмнэлгийн мэргэжилтэн цөөн байгаа нь хариуцлага тооцох боломжийг бууруулдаг.<br>• Хүний эрүүл мэндэд салбарын хэмжээнээс давсан нийгэм эдийн засгийн болон бусад хүчин зүйлс нөлөөлж байна. /хүн амын удмын сан, хоол тэжээл, ядуурал, архидалт гэх мэт/ |

**Газар зохион байгуулалтын чиг үүргийн орчны шинжилгээ**

| Дотоод орчин | |
|---|---|
| Давуу тал | • Сул тал |
| • 10 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулж батлуулсан.<br>• Хаягжуулалт, газарзүйн нэрийн тодруулгын ажлыг хэрэгжүүлж эхэлсэн. | • Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас шууд хамааралтай. |
| **Гадаад орчин** | |
| • Боломж | • Эрсдэл |
| • Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагаас газар зохион байгуулалтын талаар авч хэрэгжүүлэх чиглэл зөвлөмжүүдийг өгч байгаа. | • Covid-19-ийн нөхцөөс шалтгаалан хөрөнгө оруулалтын хэмжээ буурах магадлалтай. |

**Орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх чиг үүргийн орчны шинжилгээ**

| Дотоод орчин | |
|---|---|
| Давуу тал | Сул тал |

| | |
|---|---|
| • 17 сум дулаан хангамжийн төвлөрсөн системтэй болсон. | • Хөрөнгө оруулалтаас шууд хамааралтай |
| Гадаад орчин | |
| Боломж<br>• Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар орон сууц барих санаачилга нэмэгдсэн.<br>• ТОСК-оос төрийн өмчийн түрээсийн орон сууц барих судалгаа хийгдэж байгаа. | Эрсдэл<br>• Covid-19-ийн нөхцөлөөс шалтгаалан хөрөнгө оруулалт багасах магадлалтай. |

**Дэд бүтцийг хөгжүүлэх чиг үүргийн орчны шинжилгээ**

| Дотоод орчин | |
|---|---|
| • Давуу тал<br>• 18 суманд дэд бүтцийн суурь байгууламжууд байгуулагдсан. | Сул тал<br>• Хөрөнгө оруулалтын хэмжээнээс шууд хамааралтай.<br>• Зарим төсөл арга хэмжээний зураг төсөл батлагдаагүй. |
| Гадаад орчин | |
| Боломж<br>• Түүхэн аялал жуулчлалын тулгуур төвөөр зарлагдсан нь дэд бүтцийг өрөгтгөх, хөгжүүлэх боломжтой.<br>• Томоохон төслүүдийн хөрөнгө оруулалтын эх үүсвэр шийдэгдэж, төслийн нэгж байгуулагдсан. | Эрсдэл<br>• Дэд бүтцийн байгууламжууд их хэмжээний хөрөнгө оруулалт шаарддаг.<br>• Covid-19-ийн нөхцөөөс шалтгаалан хөрөнгө оруулалтын хэмжээ буурах магадлалтай. |
| **Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааг сайжруулах чиг үүргийн орчны шинжилгээ** | |
| Дотоод орчин | |
| Давуу тал<br>• Иргэдийн оролцоот шинэ Хэнтий төслийг амжилттай хэрэгжүүлсэн. | Сул тал<br>• ОНХС-ийн үйл ажиллагааны тайлагналт хангалтгүй. |
| Гадаад орчин | |

<table>
<tr><td>Боломж<br>• ОНХС-ийн талаар ойлголт иргэдэд төлөвшсөн.</td><td>Эрсдэл<br>• Covid-19-ийн нөхцөөс шалтгаалан иргэдийн бүлгийн уулзалт, санал авах хурал зохион байгуулах боломжгүй.</td></tr>
<tr><td colspan="2">Хариуцлагатай уул уурхайг бий болгох чиг үүргийн орчны шинжилгээ</td></tr>
<tr><td colspan="2">Дотоод орчин</td></tr>
<tr><td>Давуу тал<br>• Тусгай зөвшөөрөл олголт, цуцлалт болон бусад мэдээллийг олон нийтэд мэдээлэх аймгийн нэгдсэн цахим хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслүүд байна.<br>• Уул уурхайн компаниудын нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлэх хууль эрх зүйн орчин бүрдсэн.<br>• Томоохон үйлдвэрлэлийн төслүүд хэрэгжих боломжтой бүс нутаг, байгалийн баялагтай.</td><td>Сул тал<br>• Тусгай зөвшөөрөл олголт Төрийн захиргааны төв байгууллагад хийгддэг.<br>• Сумын Засаг дарга нар Нийгмийн хариуцлагын хүрээнд хийгддэг “Хамтран ажиллах” гэрээг хянуулдаггүй. Эдийн засгийн үр өгөөжийг тооцдоггүй.<br>• Хөрөнгө оруулалт байхгүй.</td></tr>
<tr><td colspan="2">Гадаад орчин</td></tr>
<tr><td>Боломж<br>• Мэдээллийг Төрийн захиргааны төв байгууллагаас улирал бүр авч олон нийтэд ил тод мэдээлэх боломжтой.<br>• Нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлэх арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх боломжтой.<br>• Судалгаа хийж төсөл боловсруулах боломжтой.</td><td>Эрсдэл<br>• Тусгай зөвшөөрөл олголт болон цуцлах арга хэмжээг Төрийн захиргааны төв байгууллага шийддэг тул орон нутгаас үл хамаарах эрсдэлтэй.<br>• Ковид цар тахлаас шалтгаалан уул уурхайн салбарын ААН-үүдийн хөрөнгө оруулалт, үйл ажиллагаанд хүндрэл учрах эрсдэлтэй.</td></tr>
<tr><td colspan="2">Байгаль орчин, ногоон хөгжлийн чиг үүргийн орчны шинжилгээ</td></tr>
<tr><td colspan="2">Дотоод орчин</td></tr>
</table>

<table>
<tr><td>Давуу тал<br>• Хууль эрх зүйн орчин бүрдсэн.<br>• Байгалийн нөөц ашигласны төлбөрийн хураамжаас орон нутгийн төсөвт орлого төвлөрдөг. /зарцуулах төсөвтэй/<br>• Мэргэжлийн байгууллагатай боловсон хүчинээр хангагдсан.</td><td>Сул тал<br>• Хүн амын өсөлт, хот суурин газрын төвлөрөл нэмэгдэж орчны бохирдол ихэссэн.<br>• Ажилгүйдэл, ядууралтай холбоотойгоор байгалийн баялгийн хэт ашиглалт бий болсон.<br>• Техник, тоног төхөөрөмжийн хүрэлцээ муу, шаардлага хангадаггүй.</td></tr>
<tr><td colspan="2">Гадаад орчин</td></tr>
<tr><td>Боломж<br>• Байгаль хамгаалах ажилд иргэд, олон нийтийн оролцоо сайн.<br>• Олон улсын байгууллага, бусад төсөл хөтөлбөр хэрэгждэг, хөрөнгө оруулалт сайн.</td><td>Эрсдэл<br>• Ковид цар тахлаас шалтгаалан ажилгүйдэл өсөх.<br>• Зохисгүй ашиглалтаас үүдсэн байгаль орчны хохирол нэмэгдэх</td></tr>
<tr><td colspan="2">Газар тариалан, төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлийн чиг үүргийн орчны шинжилгээ</td></tr>
<tr><td colspan="2">Дотоод орчин</td></tr>
<tr><td>Давуу тал<br>• Тариалангийн бүс нутаг тогтоох тухай ЗГ-ын тогтоол гарсан.<br>• Улаан буудайн ургац хураан авалт нэмэгдсэн.<br>• Малын тэжээл тариалалт ихсэж байна.</td><td>Сул тал<br>• Тариалангийн газар эзэмшиж авсан ч ашигладаггүй аж ахуйн нэгжүүд их байна.<br>• Хашаажуулалт хангалтгүй байна.<br>• Усалгаатай тариалангийн хэмжээ бага байна.</td></tr>
<tr><td colspan="2">Гадаад орчин</td></tr>
<tr><td>Боломж<br>• Тариалан эрхлэлтийг дэмжих сан, Олон улсын төсөл хөтөлбөрүүдээс хөнгөлөлтэй зээл, хөрөнгө оруулалт авах боломж өндөр.</td><td>Эрсдэл<br>• Цаг уурын дулаарал, цөлжилтөөс үүдэн бороо, хур бага байх.<br>• Борлуулалтын нэгдсэн суваг, цэг байхгүй.<br>• Трактор, тоног төхөөрөмж хангалтгүй.</td></tr>
<tr><td colspan="2">Мал аж ахуйн үйлдвэрлэл, мал эмнэлэг, бэлчээр хамгааллын чиг үүргийн орчны шинжилгээ</td></tr>
<tr><td colspan="2">Дотоод орчин</td></tr>
</table>

<table>
<tr><td>Давуу тал<br>• Малын тэжээл тариалалт эрчимжиж байна.<br>• Эрчимжсэн мал аж ахуй хөгжиж байна.<br>• Өөрсдөө төсвөөс гадна орлоготой /МЭГ/<br>• Улирлын тарилга, урьдчилан сэргийлэх вакцинжуулалт сайн хийгддэг /МЭГ/</td><td>Сул тал<br>• Бэлчээрийн даац хэтэрч, бэлчээр доройтолд орж байна.<br>• Сумдад лаборатори эхлэн хөгжиж байгаа. /МЭГ/<br>• Тоног төхөөрөмж нэмэлтээр их шаардлагатай байгаа./МЭГ/</td></tr>
<tr><td colspan="2">Гадаад орчин</td></tr>
<tr><td>Боломж<br>• ОУ-ын байгууллагуудтай хамтарч бэлчээр хамгаалах, сайжруулах менежментийн төсөл, хөтөлбөрүүд хэрэгжүүлэх боломжтой.<br>• Малын хөлийн татвар бий болсноор тулгамдаж буй асуудлуудыг шийдэх боломжтой.</td><td>Эрсдэл<br>• Цөлжилт, ган, зуд гэх мэт байгалийн гамшгийн эрсдэл их.<br>• Гаднаас отор нүүдэл ихээр хийгдэж ирэх.<br>• Малын халдварт, гоц халдвар өвчин гарах.</td></tr>
<tr><td colspan="2">Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиг үүргийн орчны шинжилгээ</td></tr>
<tr><td colspan="2">Дотоод орчин</td></tr>
<tr><td>Давуу тал<br>• Жижиг, дунд бизнесийг дэмжих зээл олгодог сан болон СХС байна.<br>• Түүхий эдийн нөөц ихтэй /мах, сүү, дайвар бүтээгдэхүүн, газар тариалан, төмс хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалах, ойн дагалдах баялаг гэх мэт/</td><td>Сул тал<br>• Ажиллах хүч дутмаг.<br>• Хөрөнгө оруулалт бага, эдийн засгийн хүндрэл их, зээлийн шалгуур өндөр.<br>• Ажлын байр хүрэлцээгүй, түрээс өндөр.<br>• Техник, тоног төхөөрөмж, сав баглаа боодол, үйлдвэрлэлийн хүчин чадал хангалтгүй.</td></tr>
<tr><td colspan="2">Гадаад орчин</td></tr>
<tr><td>Боломж<br>• Аялал жуулчлал эрчимтэй хөгжиж байна.<br>• Худалдаа үйлчилгээг өргөжүүлэх дэд бүтэц бий болж байна.<br>• Төр, хувийн хэвшил, олон улсын төсөл хөтөлбөрүүд хэрэгждэг.</td><td>Эрсдэл<br>• Ковид-19 цар тахлаас үүдэн худалдаа үйлчилгээ, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа саатах.<br>• Импортын бараа бүтээгдэхүүн хямд өртөгтэй, их хэмжээгээр нийлүүлэгддэг.</td></tr>
</table>

| | |
|---|---|
| • Дотоодын үйлдвэрлэлийн эрэлт хэрэгцээ их. | |

| Аялал жуулчлалыг хөгжүүлэх чиг үүргийн орчны шинжилгээ | |
|---|---|
| Дотоод орчин | |
| Давуу тал | Сул тал |
| • Түүх дурсгалын болон байгалийн онцлог бүхий газруудтай.<br>• Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт сайн хийгдсэн.<br>• Эвент арга хэмжээ тогтмол зохион байгуулагдаж хэвшсэн.<br>• Маркетинг сурталчилгаа хөгжиж байгаа. | • Дэд бүтэц хангалтгүй.<br>• Мэргэжлийн байгууллага, тур агент, тур оператор ААН байхгүй.<br>• Зочид буудал, жуулчны баазуудын хүрэлцээ муу, стандарт шаардлага хангадаггүй.<br>• Улирлаас хамааралтай. |
| Гадаад орчин | |
| Боломж | Эрсдэл |
| • Гадаад, дотоодын жуулчид өсөх<br>• Аймаг, орон нутгийн эзийн засаг нэмэгдэх, иргэд, ААН, өрхийн орлого нэмэгдэх<br>• Бүтээгдэхүүн үйлдвэрлэлүүд хөгжих | • Ковид цар тахлаас шалтгаалан жуулчдын тоо буурах<br>• Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажил удаашрах |

**Гамшигтай тэмцэх чадавхыг нэмэгдүүлэх**

| Дотоод орчин | |
|---|---|
| Давуу тал | Сул тал |
| • Онцгой байдлын газар нь хүн, хүчний хувьд үүрэг гүйцэтгэх боломж сайн байгаа.<br>• Гамшиг ослын үед шуурхай арга хэмжээг богино хугацаанд авах холбоо мэдээллийн хэрэгслээр хангагдсан.<br>• Мэргэжлийн боловсон хүчний хангалт сайн. | • Гамшгийн үед үүрэг гүйцэтгэх боломж хүн хүчний хувьд сайн боловч сүүлийн үеийн хүчин чадал бүхий хүн нэг бүрийн багаж хэрэгсэл дутмаг байдаг.<br>• Мэргэжлийн онцлогт тохирсон бэлтгэл сургуулилт хийх тоног, төхөөрөмж, тусгай зориулалтын газар байдаггүй. |
| Гадаад орчин | |

| Боломж | Эрсдэл |
|---|---|
| • Онцгой байдлын Ерөнхий газар болон аймаг орон нутаг, бусад хүмүүнлэгийн байгууллагаас хөрөнгө, санхүүгийн болон эд, матеиралын дэмжлэгийг тодорхой хэмжээгээр шийдвэрлэж үүрэг гүйцэтгэх боломжийг бүрдүүлж байдаг. | - |

**Орон нутгийн хамгаалалтын сайжруулах**

| Дотоод орчин | |
|---|---|
| Давуу тал | Сул тал |
| • Орон нутгийн хамгаалалтыг хэрэгжүүлэхэд хүн, техникийн хүрэлцээ хангалттай.<br>• Аймаг, болон сумдууд тус бүр орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөтэй болсон.<br>• Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн удирдах бүрэлдэхүүнд мэргэжлийн бүрэлдэхүүн томилгоожсон.<br>• Орон нутаг аливаа гамшгийн үеийг хохирол багатай даван туулах чадамж нэмэгдсэн. | • Хүн нэг бүрийг зэвсэг галт хэрэгслээр хангах боломж муу<br>• Өдөр тутмын дадлага сургуулилт хийх боломж бүрдээгүй<br>• Сургууль, дадлага явуулахад эдийн засгийн болон материал хэрэгслийн хувьд нөөц бүрдээгүй.<br>• Орон нутгийн хамгаалалтын мэдээллийн нэгдсэн сан бүрдээгүй. |
| Гадаад орчин | |
| Боломж | Эрсдэл |
| • МУ-ын Засгийн газар болон БХЯ-наас орон нутагт орон нутгийн хамгаалалтыг хэрэгжүүлэхэд эрх зүйн орчныг бүрдүүлсэн.<br>• БХЯ, ЗХЖШ-аас Улсын болон цэргийн дайчилгааны төлөвлөгөөг боловсронгуй болгож шинчилэн орон нутагт хэрэгжүүлэх нөхцлийг бүрэн хангаж өгсөн.<br>• Хүүхэд, залуучуудад чиглэсэн арга хэмжээний талаар онцгой анхаарч орон нутгийн холбогдох байгууллагуудыг тодорхой мэдээллээр хангаж хэрэгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж өгсөн. | • Орон нутгийн хамгаалалтын болон цэргийн дайчилгааны төлөвлөгөөнд томилгоожсон бүрэлдэхүүний эрүүл мэнд, боловсролын байдалд хяналт тавих боломж бүрдээгүй<br>• Иргэнд эх оронч хүмүүжил төлөвлшүүлэх ажил хийгддэгүй.<br>• Орон нутгийн хамгаалалтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай нөөц бүрдүүлэлт байхгүй.<br>• Эдийн засгийн хувьд биеэ дааж чадаагүй. |

## ЗУРГАА. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО

Халдварт цар тахлын хүндрэлийг амжилттай даван туулах, хүн, эдийн засаг, нийгмийн хөгжлийг хангах, байгаль орчны тэнцвэртэй байдал, засаглалыг сайжруулах, орон нутгийг хөгжүүлэх, бодлогын залгамж чанарыг хадгалах зорилготой.

## ДОЛОО. СТРАТЕГИЙН ЗОРИЛГЫГ ХЭМЖИХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, СУУРЬ БОЛОН ЗОРИЛТОТ ТҮВШИН, СТРАТЕГИ

Байгууллагын Стратеги төлөвлөгөөг доорхи бодлогын баримт бичигтэй уялдуулан боловсруулсан. Үүнд:

1. Алсын хараа 2050
2. Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл,
3. Аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл
4. Хэнтий аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр

## НАЙМ. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО БА САЛБАР, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН БҮТЦИЙН УЯЛДАА, ЗУРАГЛАЛ



БОЛОВСРУУЛСАН:

Ажлын хэсгийн ахлагч: Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга Ж.Гантулга

Нарийн бичиг: Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн С.Оюун-Эрдэнэ

Гишүүд:
Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Б.Дарханбаатар
Нийгмийн бодлогын хэлтсийн дарга Г.Лхагвахатан
Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн Б.Мөнх-Эрдэнэ
Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Мөнхжаргал
Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн Г.Уянга
Цэргийн штабын офицер Л.Цэнддорж
Хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудитын хэлтсийн мэргэжилтэн Б.Хүрэлзүрх
Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн М.Дэлгэрзаяа